

Living the Lotus

6
2022

VOL. 201

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

**Living the Lotus
Vol. 201 (2022.06)**

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Туршлага бол бусдыг итгүүлэх чадварын үндэс

Буддизмын Тэндай урсгалын тэргүүн асан Ямада Этэй гуай намайг “Нивано та аливаа зүйлийг заалгангуутаа л маргаашнаас нь хэрэгжүүлж эхлэх юм. Энэ бол тун чухал чанар шүү” гэж магтаж билээ. Намайг ийм болоход нөлөөлсөн үлгэр дууриал бол Шагжамүни бурхан юм. Тэрээр Цагаан лянхуа сударт “Би сургаалыг сонссон даруйдаа хэрэгжүүлдэг байсан болохоор гэгээрэлд хүрч чадсан” хэмээн өгүүлсэн байдаг.

Залуучуудын бүлгэмийн лидер гишүүн надаас “Явал өөртөө итгэлтэйгээр сургаал айлддаг болох вэ?” гэж асууж байсан удаатай. Үүнийг тийм хүндээр бодох хэрэггүй. Мөн тийм олон зүйлийг ч сураад байх шаардлагагүй. Зүгээр л сонсож мэдсэн зүйлээ шууд хэрэгжүүлдэг байх хэрэгтэй. Ингэснээр ямар нэгэн зүйлийг ойлгож сурч авдаг. Хүн өөрийн биеэр хийж үзсэн зүйлээ өөртөө итгэлтэйгээр бусдад тайлбарлаж чаддаг. Үүнийг л хэрэгжүүлээд байхад болно. Өөртөө итгэлгүй байдал нь туршлага байхгүйгээс үүдэлтэй.

Жишээлбэл “Хүнийг өөрчилмөөр байвал эхлээд өөрөө өөрчлөгдөх хэрэгтэй” гэж сурлаа гэж бодоход үүнийг хэрэгжүүлж үзэхгүй л бол үнэхээр тийм эсэхийг нь мэдэх аргагүй. Бурханы сургаалыг амьдралдаа хэрэгжүүлж үзэж байж л “Нээрээ тийм юм байна шүү дээ” өөрийн биеэр гэж ойлгож мэдэрдэг. Иймээс туршлага бол бусдыг итгүүлж үнэмшүүлэх чадварын эх үндэс юм.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X190-191

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Энэрэнгүй сэтгэлээр “Хүлцэнгүй” 2-р хэсэг

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Дээдийн хүлцэнгүй чанар

Буддизмын Зэн урсгалын багш Рёокан (1758-1831)-ны “Магтуулж, муулуулах уг сонсох аваас энэ биеэ эргэцүүл. Учирсан хүн бол өөрийгөө харах толь болой.” хэмээх дууны шүлэг бий. Хүн өөртэй нь хэрхэн харилцаж, хандаж байгаагаар өөрийнхөө ямар байсныг эргэцүүлэн бодохыг сургадаг “бусдын хандлагыг хараад өөрийн биеэ зас” гэсэн зүйр үгтэй төстэй утгатай боловч энэ шүлэг нь илүү нарийн гүнзгий утгыг агуулдаг бололтой.

Рёокан багштан энэ шүлэгээрээ дамжуулан “Өөрийг нь муулах юм уу магтах үед уурлаж бухимдан, хөөрч бардамналгүй өөрийнхөө байгаа байдлыг гүнзгий эргэцүүлэн бодох хэрэгтэй” хэмээн өөртөө хэлж сануулдаг байсан болов уу. Намайг тэгж харж байна гэдэг нь тэгж бодогдуулахаар ямар нэгэн зүйл надад байна гэсэн үг бус уу хэмээн.

Ийнхүү өөрийгөө эргэцүүлэн бодох нь сэтгэл хөөрлөө дарах хүлцэнгүйн барамидыг хэрэгжүүлж байгаатай адил хэмээн уг шүлэг сургана. Рёокан гуайг хүүхэд хөгшидгүй хүндлэн хайрладаг байсан боловч үүнд нь дургүйцэн атаархах хүн ч байжээ.

Нэг өдөр Рёокан гуайд үргэлж атаархаж явдаг нэгэн хувраг шал согтуу шавар шавхай болсон байдалтай хүрч ирээд гэнэт түүнийг бүсээрээ цохиж эхэлжээ. Харин Рёокан гуай нөхцөл байдалд биеэ даатган зодуурыг хүлцэн тэвчжээ. Арай хийн бэрхшээлийн ард гартал тэр оройжингоо бороо орж гэнэ. Тэгтэл Рёокан гуай “Нөгөө хувраг борооны цувтай явсан байгаа даа” хэмээн амандаа бувтнасан гэдэг.

Өмнөх сарын дугаарт хүлцэнгүйн барамид гэдэг нь хүчээр өөрийгөө барьж тэвчих бус аливаа зүйл, хүнийг зүгээр л хүлээн зөвшөөрч ойлгохыг хэлнэ гэж хэлсэн. Ойлгож хүлээн авах сэтгэл дээр нэмээд энэрэн нигүүлсэх сэтгэл нь хүлцэнгүй барамидыг хэрэгжүүлэх чухал хүчин зүйл, түлхэц болдгийг саяны ярианаас ойлгож болно.

Үүсгэн байгуулагч «Лянхуан Гурамсан Сударын шинэ тайлбар» номондоо “Бурханы сургаал сонссоноор бусадтай нэгэн бүхэл мэдрэмж гүнзгийрч, алив

зүйлийг хөндлөнгөөс харах зуршилтай болдог. Улмаар хүлээцтэй тэвчээртэй чанар сууж, бусдын нөхцөл байдлыг ойлгодог болдог тул уурлаж бухимдах, үзэн ядах сэтгэл төрдөггүй. Эсрэгээрээ энэ хүн ямар өрөвдмөөр юм бэ, энэ буруу сэтгэлийг нь засан залруулж өгөх юмсан гэсэн энэрэнгүй сэтгэл төрдөг болдог” гэж бичсэн байдаг ба үүнийгээ “Дээдийн хүлцэнгүй чанар” гэж хэлсэн байдаг.

Хэсэгхэн зуур ч болов бурханы сургаалыг санах

Амьдралд зовлон бэрхшээл, уйтгар гунигтай үйл явдлаар дамжуулан чухал зүйлийг олж анзаарах тохиолдол байдаг. Рёокан гуайн “Хүлцэнгүй сэтгэл бол ач буяны үндэс” гэсэн бас нэгэн бичвэр бий. Энд хэлж буй “ач буян” гэдэг нь тийм уйтгар гунигтай үйл явдлаар дамжуулан ойлгож ухаарсан зүйлийг хэлж байгаа болов уу. Хүлээн зөвшөөрөхөд хэцүү зүйлээс зугталгүй нүүр тулж, хүлээн авч ойлгосноор сэтгэлийн цар хүрээ бага багаар тэлсээр аливаа зүйлийг уян хатан хүлээж авдаг болох гэсэн ач буяныг эдэлнэ гэсэн үг. Түүнчлэн өөртөө маш хайртай байдаг хүмүүс бидэнд зовлон бэрхшээл нь “би явцуу бодож байжээ” хэмээн өөрийгөө олж анзаарах, энэ амьдралдаа дахин шинээр төрөх маш том боломжийг өгдөг. Энэ ч гэсэн хүлцэнгүйн барамидын гайхамшигтай ач буян юм.

Үүнийг ойлгож байгаа ч гэсэн би бол Бурхан багш шиг тийм уужуу тайван сэтгэлээр хүлцэнгүйн барамидыг хэрэгжүүлж чадахгүй гээд буугаад өгчихсөн хүн байж ч болох юм.

Гэхдээ Рёокан гуайн амьдралын замналаас харахад өнгөрсөндөө баригдахгүй байх, тоглож наадахдаа ч гэсэн яг түүндээ төвлөрөх, хүний үгийг байгаагаар нь хүлээж авч сонсох, аливаа зүйлийг өөр дээрээ тусган бодож өөрийгөө эргэцүүлэн бодох зэргээр тухайн цаг мөч, нөхцөл байдалд бурханы сургаалыг хэсэгхэн хугацаанд ч болов санах төдийд Цагаан лянхуа сударт “Түүнчлэн ирсэний өмсгөл” гэж гардаг “уян зөөлөн хүлцэнгүй сэтгэл”-ыг эзэмшиж чадах юм шиг санагдаж байна. Хүлцэнгүйн барамидыг хэрэгжүүлэх тулгуур болдог нигүүлсэхүйн сэтгэлийг чухалчлах хэрэгтэй гэдэг нь ч гэсэн бусадтай нэгэн бүхэл гэсэн хандлагаар хүнтэй чин сэтгэлээсээ харилцахаа мартахгүй байхад л болох юм. Угаасаа бид бурханлаг чанартай шүү дээ.

Төгсгөлд нь дахиад нэг Рёокан гуайн шүлгийг танилцуулъя. “Дэн буудлын өрөөний ургамалыг аалзны тор бүрхжээ. Явж очоод цэвэрлэе гэж бодсоноо тэр дороо болихоор шийдэв.” Дургүй зүйлдээ ч гэсэн нэгэн бүхэл гэсэн сэтгэлээр хандаж, хүндэтгэх. Үүний үр дүнд энх тайван ирнэ гэдэгт би итгэнэ.

“Косей” сэтгүүл, 6-р сарын дугаар

Итгэл алдарсны эцэст ойлгосон бусдын ач тус

Кога нийгэмлэгийн гишүүн
Кикүчи Ёсүкэ

*Энэхүү илтгэл нь «Косей» сэтгүүлийн 2022 оны 3-р сарын дугаарын
“Сүсэг биширэл бүхий амьдрал - амь нас ба шинэ амьдрал” буланд нийтлэгдсэн болно.*

Токио хотод нэгэн компанид мэдээллийн технологийн инженерээр 6 дахь жилдээ ажиллаж байхад 25 насны хавар бие маань нэг л биш байгааг анзаарсан юм. Өглөө ажилдаа явахаар бэлдэж байтал гэнэт дотор муухайран, бие сульдаж, юм хийх хүсэл төрөхгүй байв. 2 хоног амарсан боловч огт дээрдсэнгүй. Эмнэлэгт үзүүлэлт сэтгэл гутралд орсон гэж оношлогдон, ажлаас 3 сар амар гэв.

Тухайн үед би нэгэн харилцаа холбооны компанийн программ хөгжүүлэлтийг хариуцан 4 хүнтэй багийг ахлан ажиллаж байлаа. Удаан хугацаагаар илүү цагаар ажиллахын зэрэгцээ шинэ залуу ажилчдыг сургадаг байсан ч илүү цагийн хөлс авдаггүй мөн өндөр боловсролтой залуу ажилтангуудын цалин минийхээс өндөр байв. Өөрийгөө шударгаар үнэлүүлж чадахгүй байгаагаас болж компанидаа сэтгэл дундуур байсан нь миний сэтгэлийг зовоож, архи уухгүй л бол унтаж чадахгүй байдлаар хэдэн жилийг өнгөрөөсөн. Ингээд л эцэст нь сэтгэцийн өвчин туссан байлаа.

Би амарч байхдаа автомат тоглоомын газраар хоног төөрүүлж байв. Учир нь мөнгөлөг бөмбөгийг нүдээрээ элдэн сууж байхад сэтгэл сэргэдэг байсан юм. Гэвч шөнө дунд гэртээ ганцаараа байхдаа өвдөөд ажил хийж ч чадахгүй сул дорой байгаадаа гутарч, өөрийн мэдэлгүй бугуйгаа цаасны хутгаар гэмтээх үе ч байв. Гэсэн ч би бардам зантайн дээр бусдад сул дорой байдлаа харуулахыг хүсдэггүй байсан тул хэн нэгэнтэй ярилцаж зөвлөлдөхийг хүсдэггүй байлаа. Амрах хугацаанд биеийн байдал сайжралгүй, ажил хийх урам зориг байхгүй болсон учраас 2008 оны 7 сард өөрийн хүсэлтээр ажлаасаа гарав.

Үүний дараа автомат тоглоомонд донтож, өндөр хүүтэй мөнгө зээлдүүлдэг банк бус санхүүгийн байгууллагаас мөнгө зээлэн их хэмжээний өрөнд орлоо. Байрны мөнгөө ч төлж чадахгүй болох үед л ээждээ (Ёшиэ, 72 настай) анх удаа нөхцөл байдлаа хэлсэн юм. Ээж минь

“Ямар ч байсан гэртээ хүрээд ир” гэснээр би 2012 оны 2 сарын эхээр Ибараки мужын Сакай хот дахь төрсөн гэртээ ирсэн юм.

Аав ээж маань том ахынхантай (45 настай) амьдардаг ба хүнсний ногооны тариалан эрхэлдэг. Ээж маань миний өмнөөс банкны өрийг төлж, би байрны түрээсийн төлбөрөө барагдуулахаар болж мөнгөний асуудал шийдэгдсэн ч дотроо “Би өвчин туссан учраас аргагүй байсан шүү дээ” гэж бодон эцэг эх, ахын гэр бүлийнхэнд огт талархдаггүй байлаа. Гэр бүлийн ресторанд цагийн ажил хийж бусад үед өрөөндөө бүтэн интернэт ухаж эсвэл архи уун унтаж өдрийг өнгөрөөж байв.

Тэр үед нойргүйдэлд орж арваад төрлийн эм ууж байсан ч шар айраг ихээр уун эмээ буцаан урсгаж гаргаад өөрөө өөрийгөө л дордуулж байлаа. Нэгэн өглөө ногооны талбай руу явж байхад аав маань “Сэтгэл санаа чинь л асуудалтай байгаагаас биш чи өвчин тусаагүй. Тиймээс жаахан ч гэсэн гэрийнхээ ажилд тусалж



*Кога нийгэмлэгийн 60 жилийн ойн
баяр дээр илтгэл тавьж байгаа нь*

хөлсөө урсга” гэж хатуу зэмлэсэн юм. Аавынхаа үгнээс өөрийгөө гэрийнхэндээ гай болж байна гэж ойлгон улам ихээр ганцаардах болов.

Хэдэн жилийн дараа хувийн эмч маань байдаг Сайтама мужийн Кошигая хотод ганцаараа амьдарч эхэллээ. Аахар шаахар өдрийн ажил хийн амьдарч байхдаа А гэдэг хүнтэй олон нийтийн сүлжээгээр дамжуулан танилцав. Надтай адилхан өвчнийг туулсан тэрээр миний зовлонг хуваалцдаг байсан тул олон жил мэдрээгүй сэтгэлийн тайвшралыг мэдрсэн юм. Хэсэг хугацааны дараа А гуай надаас “Хирошима мужид органик бордоо үйлдвэрлэх бизнес эхлүүлсэн тул вэб хуудас хийхэд тусалж өгөөч” гэж хүсэв. Хэн нэгэнд хэрэгтэй байгаадаа баярлаж бас гэр бүлийнхэндээ амжилттай яваагаа харуулмаар байсан тул зөвшөөрөв. Ингээд 2014 оны 6 сарын сүүлээр Хирошимад очлоо.

А гуай дасаагүй шинэ газарт амьдрахад тусалж байсан боловч миний сэтгэл гутралын өвчний эмийн сөрөг нөлөө хүчтэй байсан тул эмээ зогсоохыг надад хэд хэдэн удаа зөвлөлөө. Гэвч эмээ уухаа болингуут хөлөрч, нүүр таталдаж, сэтгэцийн эмгэгийн шинж тэмдэг илрэн ажлаа хийж чадахгүй болдог байв. Тэр үед А гуай над руу уурлан хашхирч заримдаа гар хүрэх явдал ч байлаа. Ажиллаж эхлээд 5 сарын дараа буюу 11 сарын сүүлээр би тэсэлгүй утсаа унтраан ямар ч зорилгогүйгээр хурдан галт тэргэнд суув. Очсон газар маань Осака хотын энгийн нэгэн буудал байлаа.

Одоо үхэхээс өөр арга алга. Эцсийн найдвар А гуайтай холбоо тасарч сэтгэл минь цөхрөлөөр дүүрсэн байв. Төрсөн нутаг руугаа буцмаар байсан ч гэр рүүгээ залгах зориг хүрэлгүй, орой болгон утсаа хэдэн минут асаан дуудлага ирэхийг хүлээн суудаг байлаа.

Осакад нуугдан 7 хоног өнгөрсний дараа 11 сарын 28-ны орой гар утсаа асаатал дуудлага орж ирсэн нь Рисшо Косей Кай—Кога нийгэмлэгийн дарга (тухайн үеийн) Хагивара Юкимаса гуай байлаа. Загнуулна даа гэж эмээн утсаа автал Хагивара дарга “Ёосүкэ, хаана юу хийж байна? Гайгүй юу?” гэж аядуухнаар асуув. Сэтгэл минь амран Хирошимад болсон явдлыг нэг нэгэнгүй яриад “Тэр бүлийнхэнтэйгээ уулзах нүүр байхгүй” гэж буцах бодолгүй байгаагаа хэлэв. Тэгсэн хэдий ч нийгэмлэгийн дарга намайг ирэхийг ятган “Чамайг хүлээж байгаа шүү” гэж хэлэхэд нь нулимс асгаран буцахаар шийдсэн юм.

Гурав хоногийн дараа Кога нийгэмлэгийн хаалгаар явж ортол Хагивара дарга угтан авлаа. Хажууд нь хөшчихсөн царайтай аав, уйлахын наагуур байгаа ээж маань зогсож байв. Аав ээжийнхээ царайг харан сэтгэл амрахын зэрэгцээ газрын гаваар орчмоор л санагдаж байлаа.

Даргын өрөөнд орон аав ээжтэйгээ өөдөөс нь харан суухад аав маань босч “Хүүг маань төвөг удсанд өршөөгөөрэй” хэмээн уучлал хүсэн толгойгоо бөхийлгөв. Дарга аавыг суудалдаа суухыг уриад надад хандан “Цаашид яая гэж бодож байна даа?” гэж асуулаа. Үг дуугарч чадахгүй байгаа намайг гэртээ харихыг ятгасан боловч гэрийнхэн маань “гай удагч”-ыг хүлээн авна гэж бодохгүй байсан тул зөвшөөрсөнгүй. Би өөрөө ч тийм шаналгаатай байдалд орохыг хүсэхгүй байсан юм.

Би толгой бөхийлгөсөн чигээрээ “Гэртээ харьж чадахгүй” гэдгээ ний нуугүй хэлэхэд дарга нийгэмлэгийн шөнийн жижүүр хийхийг санал болгов. Шөнийн жижүүр гэдэг нь тухайн үеийн бурханы үйлийн нэг бөгөөд нийгэмлэгт хонож, өглөө оройдоо судар уншин бясалгаж, өргөөг харж хамгаалах ажил юм. Ээж үүнийг сонсоод “Энэ хүүхэд шөнийн жижүүр хийж чадах болов уу гэдэгт санаа зовж байна. Гэхдээ таньд найдаж үлдээ” гэж уйлан хэлж харин аав таг дуугүй суусаар байв. Ээжийгээ уйлуулж, аавыгаа ичээж, нийгэмлэгт төвөг удаж буй өөрийгөө бодохоор “гай удагч” гэсэн бодол



Цэцэрлэгжүүлэлтийн ажил хийж байгаа нь

Spiritual Journey

минь улам хүчтэй болж байсан. Үүний зэрэгцээ над шиг хүнээс нүүр бууруулалгүй хонох газар гаргаж өгч буй Хагивара даргын сэтгэлийг бодохгүй бол болохгүй гэсэн бодол ч бас төрсөн юм.

Надад энэ үүргийг авахаас өмнө заавал шийдэх ёстой нэг зүйл байсан нь А гуайг юу ч хэлэлгүй орхиж явсан явдал байлаа. Маргааш нь энэ талаар даргатай ярилцахад “Тэр хүнээс тусламж дэмжлэг авсан нь үнэн юм чинь талархах нь зүй ёсны хэрэг шүү. Эцэг эхтэйгээ очоод баярлаж талархсанаа илэрхийлбэл яасан юм бэ” гэж зөвлөлөө. Тэгээд 12 сарын 14-ний өдөр аав ээжийгээ дагуулаад А гуайнд очсон юм.

Би түүнээс ажлаа гэнэт хаян явсандаа уучлалт гуйж хагас жил гаруй халамжилж байсанд нь талархлаа илэрхийлэв. Тэгэхэд тэрээр “Эцэг эхтэйгээ уулзсан чинь сайн зүйл болжээ” гээд мөрөн дээр минь гараа тавиад инээмсэглэж билээ. Надад сэтгэл тавьж байсан А гуайн сэтгэлийг ойлгож чадаагүй өөрийгөө хичнээн амиа хичээсэн хүн болохыг тэгэхэд л анзаарсан юм.

Тэр үед надтай хамт Хирошима хүртэл явж ирсэн аав ээждээ ч бас адилхан хандсанаа ойлгож буцах замдаа галт тэргэнд зориг гарган уучлал гуйлаа. Тэгэхэд аав нүд рүү минь харан “Өнгөрсөн зүйлд шаналахаас илүү ирээдүйгээ бодож тунгаа” гэсэн ганцхан өгүүлбэр хэлсэн. Харин ээж маань гартаа барьсан сэтгүүл рүү харан “Дараа энд аялалаар ирээд амттай хоол идэх юмсан ” гээд юу ч болоогүй юм шиг хэлж билээ. Өнгөрснийг асууж шалгаан сэтгэлийг минь шаналгахгүй гэсэн эцэг эхийнхээ сайхан сэтгэл, хайр халамжийг мэдрэхийн хажуугаар өөрийгөө “гай удагч” гэж бодож байсандаа ичин дотроо маш ихээр өршөөл эрж байв.

Нийгэмлэгт буцаж ирээд амьдралаа шинээр эхлэх бодолтойгоор шөнийн ээлжийн үүргээ хийж эхэлсэн. Би нийгэмлэгийн хоёр дахь үеийн гишүүн ба сурагчдын бүлгийн үйл ажиллагаанд оролцсоноос хойш нийгэмлэгээс хол байсан тул энэ үүрэг нийгэмлэгийн анхны дадлага маань болов. Бурхан тахилд идээ өргөх, судар унших дэг жаяг зэрэг мэдэхгүй зүйлс олон байсан ч номын андуудаас зааж өгөхийг гуйхад бүгд эелдгээр хэлж өгнө. Аав ээжийн минь үеийн нийгэмлэгийн гишүүд “Хамтдаа хичээгээд бурханы сургаалыг хэрэгжүүлцгээе” гэж хэлэхэд нь нийгэмлэгт эргэж ирсэндээ баярлах сэтгэл төрж байлаа.

Шөнийн ээлжийн үүргээр дамжуулан сурсан зүйл бий. Нэгэн өглөө нэлээн ядарсан байрын

ахмад гишүүнийг уншлага эхлэх 6 цаг хүртэл сэрээгээгүй юм. Гэтэл тэр хүн “Би бурханы үйлийг хэрэгжүүлэх үүрэг аваад шөнийн ээлжинд гарч байгаа учраас сэрээхээс санаа зовох хэрэггүй” гэв.

Тэр үгийг сонсоод компанид багийн ахлагчаар ажиллаж байсан маань санаанд оров. Төвөгтэй ажлыг өөрөө хийх нь хурдан учраас залуучуудаар хийлгэдэггүй байсан нь тэдний ажлын туршлага хуримтлуулах боломжийг булаахаас гадна өөртөө ч ажил нэмж стресс үүсгэж байжээ гэж ухаарав. Мөн амиа хичээж байсан өөрийгөө дахин олж харсан юм.

2007 оны 1 сараас Ибараки мужын Кога хотод байр хөлслөн талхны цехэд цагийн ажил хийж эхэлсэн ба шөнийн жижүүрээ үргэлжлүүлэн хийсээр байв. Тэр үед шөнийн ээлжинд хамт гарч байсан Кооичиро Айзава гуай (74) өөрийнхөө цэцэрлэгжүүлэлтийн компанид ажиллахыг урьсан юм. Гэвч би сэтгэл гутралаар өвдөж байсан болохоор тийм биеийн хүчний ажил хийж чадах эсэхдээ эргэлзэж байлаа.

Хагивара даргатай зөвлөлдөхөд “Ирээдүйдээ санаа зовон хөдлөхгүй байх нь хэт хянуур зан, өнгөрсөндөө баригдан хөдлөхгүй байх нь баригдмал сэтгэлгээтэй байгаагийн илрэл юм. Косей Кай бидэнд одоог чухалчлан амьдрахыг заадаг” гэж сургамжлав. Үүнийг сонсоод би өөрийгөө заавал өөрчилнө гэж тангарагласнаа эргэж санан үл таних ертөнц рүү шумбан орохоор шийдлээ.

Өглөө бүр 6 цаг хагаст шөнийн ээлжээ дуусгаад хажуугийн хотод байдаг Айзава гуайн компани руу жижиг ачааны машинаар очоод орой болтол ажлын талбайгаар тойрон явна. Цэцэрлэгийн зэрлэг ургамлыг хадаж, гудамжны



Нийгэмлэгийн нэвтрүүлгийн өрөөнд ёслолын ажиллагааг дамжуулахаар бэлдэж байгаа нь

моддын мөчрийг засаж янзлан ажил дуусахад туйлдатлаа ядарсан байдаг байлаа. Гэвч зуны халуунд ажиллаж байхад эргэн тойрны хүмүүсээс “Үргэлж цэцэрлэгийг сайхан болгож өгдөгт баярлалаа” гэсэн талархлын үг сонсоод ядаргаа маань ор мөргүй арилна. Ингэж биеийн хүчний ажил хийгээд шөнө эмэнд найдалгүй нам унтаж, хоолоо хүртэл амтархан иддэг болсон.

Үүний зэрэгцээ нийгэмлэг дээр видео бичлэг засч найруулах үүрэгтэй боллоо. Баяр ёслол, арга хэмжээ, санга нарын яриаг багтаасан видео бичлэгийг гишүүд маш сайхнаар хүлээн авч надад ч бас өгөөжтэй санагдаж байв.

Цэцэрлэгчийн ажил, нийгэмлэгийн үүргээр дамжуулан өөрийгөө бусдад хэрэгтэй гэдгээ ойлгох үед “Би ч дээ...” гэсэн өөрийгөө дорд үзэх сэтгэл маант алга болсон юм. Бас зорьж байгаад дундаас нь шантарсан системийн инженер болох хүсэл маань эргэн сэргэсэн тул өнгөрсөн жилийн 8 сараас эхлэн амралтын өдрүүдээр л цэцэрлэгийн ажилд туслан бусад үед чөлөөт инженерээр ажиллах болж амьдрал маань өөрчлөгдсөн.

Мөн корона дэгдсэн өнгөрсөн жилийн сүүлээс Кога нийгэмлэгийг дижиталжуулах ажлыг хариуцах болж нийгэмлэгийн үйл ажиллагааг гишүүдэд дамжуулах ажлыг явуулж байна.

Би энэ ажлыг, үүргийг “Бодьсатвагийн үйлийг хэрэгжүүлэх газар” “Хүмүүсийн ачийг хариулах боломж” гэж үздэг. Энэ нь эцэг эх, санга нараас авахуулаад надтай учирсан олон хүмүүсийн ачаар өөрийгөө бусдад хэрэгтэй гэдгийг ойлгосон учраас юм. Энэ баяр баясгаланг зүрх сэтгэлдээ тээгээд ажил үүрэгтээ улам шамдая гэж бодож байна. Баярлалаа.



Нийгэмлэгийн номын өргөөнд санга нарын хамт

Рисшо Косей Кай Нийгэмлэг (Зурагт ном)

Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

Ханхүү болон мэндэлсэн нь

Шагжамүни бурхан одоогоос 2500 гаруй жилийн тэртээ Энэтхэгийн Лүнбинид (одоогийн Балбын нутаг дэвсгэр) Шагжа овгийн ханхүү болон мэндэлжээ.

Түүний ээж Маяа хатан тэнгэрээс 6 соёт цагаан заан буун ирээд хэвлийд нь оров гэж зүүдэлснээр бие давхар болсоноо мэдсэн гэдэг. Гэвч Маяа хатан төрснөөсөө 7 хоногийн дараа ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн тул Шагжамүни бурханыг ээжийнх нь дүү охин өсгөжээ. Шагжамүни бурхан төрөнгүүтээ дөрвөн зүгт долоо, долоо алхаад “Тэнгэр газар дээр зөвхөн би л гайхамшигтай” гэж хэлсэн хэмээн домогт өгүүлдэг.



Бяцхан мэдлэг

Шагжамүни гэдэг нь “Шагжа овгийн гэгээнтэн” гэсэн утгатай ба “Шагжамүни бурхан” хэмээн хүндэтгэн дууддаг. Тэрээр МЭӨ 462 онд (566 он, 624 он ч гэж хэлдэг) төрсөн ба 80 настайдаа ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн гэгддэг.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Сахил хүртэхээр шийдсэн нь




Шагжамүни бурхан ханхүү байхдаа шилтгээнийхээ зүүн хаалгаар тоглохоор гараад нэгэн настай хүнтэй таарчээ. Бас нэг өдөр урд хаалгаар гартал өвчтэй хүнтэй, баруун хаалгаар гартал оршуулах ёслолтой таарав. Харин хойд хаалгаар гарч яваад нэгэн ламтай таарч, ламын гэгээн дүр төрхийг хараад сэтгэл нь хөдөлж лам болохоор шийджээ. Хүн хэзээ нэгэн цагт хөгширч, өвдөж эцэст нь үхэлтэй нүүр тулдаг ажээ. Энэ зовлонгоос ангижрахын тулд яах ёстой вэ? Энэ бол Шагжамүни бурханыг сахил хүртэж, зөв зам мөрийг эрэлхийлэхэд хүргэсэн “Дөрвөн хаалганы түүх” гэдэг домог юм.



Бяцхан мэдлэг

Шагжамүни бурхан даяанчлахаар явахдаа дагуул Чандакагийн хайртай морь Кантакаг унан цайзаасаа гарчээ. Шөнөжин давхиж өглөөний нарнаар нутгийн хил дээр морио буцаасан бөгөөд хайрт морь нь цайздаа эргэж ирээд гунигт автан өөд болсон гэсэн яриа байдаг.



Олон улсын хэлтсийн даргын булан

Дээдийн хүлцэнгүй чанар гэдэг нь

Саяхан л шинэ жил эхэлж байсан мэт санагдавч аль хэдийнээ хагас жилийг тойрчээ. Цаг хугацаа хичнээн хурдан өнгөрч буйг эдгээр өдрүүдэд мэдэрч байна.

Энэ сард ч гэсэн Нивано ерөнхийлөгчийн айлдвараас “Хүлцэнгүйн барамид”-ын тухай ойлголтоо гүнзгийрүүлэх боломж олдлоо. Юуны түрүүнд “Дээдийн хүлцэнгүй чанар” гэсэн сэдэв миний сэтгэлийг онцгой хөдөлгөсөн. Энэ хэсэгт Үүсгэн байгуулагчийн “Бурханы сургаал сонссоноор өөрийгөө болон өрөөлийг нэгэн бүхлээр мэдрэх мэдрэмж гүнзгийрч энэрэн нигүүлсэх сэтгэл төрдөг” гэсэн сургаалын талаар дурджээ. Косей Кай нийгэмлэгийн бурханы зам мөрийг хэрэгжүүлж буй хүмүүсийн цөөнгүй нь хэдийн үүнийг мэдэрсэн болов уу. Энд дурдсан “бусадтай нэгэн бүхэл” гэсэн мэдрэмж гэдэг нь ойлгож хүлээн зөвшөөрөх сэтгэлийг илэрхийлж байгаа ба бид үүнийг л зорих ёстой гэж бодож байна.

Эсрэгээрээ бид энгийн үед би ба бусад, сайн ба муу гэх зэргээр аливаа зүйлийн өнгөн талыг нь харан үнэлж дүгнэдэг байж магадгүй. Ийм нэг талыг барьсан үзлээс салж чадахгүй байгаа эгэл хүмүүс бидний сэтгэлийг бурханы сургаал аажмаар “Дээшээ бодьсадвагийн гэгээрэл рүү тэмүүлж, доошоо хамаг амьтныг аврахыг зорих” гэсэн бодьсадвагийн зам мөр рүү чиглүүлдэг юм байна. Энэ сарын айлдвараар дамжуулж бурханы үйл нь ийнхүү бидэнд гэгээрэлд хүрэх арга замыг зааж өгдөг юм байна гэдгийг ойлгосон билээ.


Кэйичи Акагава



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
(Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
TEL: 1-650-359-6951 Email: lotusbuddhist@gmail.com
URL: <https://sf-buddhism.org/>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
TEL: 1-773-842-5654
Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
(Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
Email: info@rkina.org
URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
(Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
Email: dharmasanantonio@gmail.com
URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部**Korean Rissho Kosei-kai of Busan**

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan

台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rampur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhil****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroov-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: https://www.rkuk.org
Facebook: https://www.facebook.com/rkuk.official
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: http://www.ibt-rk.org